

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/80/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 280512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn Ахлах аудитор: П.Батцэцэг Утас: 260512 Цахим хаяг: battsetsegp@audit.gov.mn Дөлгөөнхайрхан уул Аудит ХХК-ийн захирал: Б.Пүрэвдулам Утас: 70005711 Цахим хаяг: dulguunkhairkhanuulaudt09@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	6
<b>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан</b> .....	6
<b>2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан</b> .....	6
<b>2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан</b> .....	7
<b>2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан</b> .....	8
<b>2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл</b> .....	9
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
<b>3.1 Компани, түүний үйл ажиллагаа</b> .....	11
<b>3.2 Компанийн гадаад, дотоод орчин</b> .....	11
<b>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал</b> .....	11
<b>3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт</b> .....	12
<b>3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл</b> .....	13
4.АУДИТЫН ТАЙЛАН .....	15
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	15
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	15
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	15
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	15
<b>4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	16
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
<b>5.1 Албан шаардлага</b> .....	17
6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	19
<b>6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл</b> .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМНДШ	Эрүүл мэндийн нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ГШБ	Гэрээ шууд байгуулах
ШХА	Шууд худалдан авах



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026. 03. 23 № 06/773  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (АДБОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 289.2 сая төгрөгийн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

- Худалдах, худалдан авах 17.9 сая төгрөгийн гэрээг харьцуулсан судалгаа хийлгүйгээр зах зээлийн үнээс өндөр үнээр авсан;
- Нийт 260.0 сая төгрөгийн 2 гэрээг нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар байгуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гэрээг байгуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт гэрээний хувийг, уг аргыг хэрэглэх болсон үндэслэлтэй хамт хүргүүлээгүй;
- Тайлант оны дотоод томилолтоор явсан автомашины шатахууны зардалд нийт 11.3 сая төгрөгийг зарцуулсан, томилолтоор явахдаа ашигласан автомашины мэдээлэл байхгүй;

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 48 дугаар зүйлийн 48.7, Төрийн хэмнэлийн тухай хуулийн 4

Z:\Yawsan\_Bichig\2026\0316 SAG-53.Docx

1526141178

дүгээр зүйлийн 4.2.7, Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 3.2 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангаагүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2024 оны 32 дугаар тогтоолоор хуралдааны тэмдэглэлд “Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон түүний харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх” гэж даалгасны дагуу ажилчидтай орон сууцны урьдчилгаа олгох гэрээ байгуулан урьдчилгааг олгосон. Тус гэрээний 4.1-д таван жилийн хугацаа дуусахаас өмнө албан хаагч төрийн бусад байгууллагад сэлгэн, эсхүл шилжин ажиллах болсон, сахилгын шийтгэлээр ажлаас халагдсан, өөрийн санаачлагаар төрийн албанаас чөлөөлөгдсөн тохиолдолд гэрээний 2.2.1-д заасан төлбөрийг бүрэн төлж дуусгана гэсэн заалтыг үндэслэн өөр байгууллагад шилжин ажиллахаар болсон 4 албан хаагчийн орон сууцны урьдчилгаа болох 282.2 сая төгрөгийг бусад богино хугацаат авлага дансанд бүртгэж тайланд тусгасан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж, ахуйн байнгын хорооны 2025 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд тусгасан зах зээл дээрх ноолуурын худалдан авалтыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн 12 хувийн хүүтэй 500,000.0 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний энгийн вексель гаргах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Голомт банк”, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь “Ханбогд кашимер” ХХК, “Говь” ХК нартай тус тус 7,000.0 сая төгрөгийн “Ноолуурын худалдан авалтыг дэмжиж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх дөрвөлсөн гэрээ”-г байгуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	424,767,663.75	2,803,269,940.70
1.1.2	Дансны авлага	2,173,640,529.40	2,461,614,128.57
1.1.4	Бусад авлага	17,040,317.00	201,507,000.00
1.1.6	Бараа материал	42,821,271.10	2,618,416.42
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	10,462,170.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,658,269,782.25</b>	<b>5,479,471,655.69</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,917,022,400.74	1,660,291,819.81
1.2.2	Биет бус хөрөнгө	1,243,816,385.01	1,059,012,739.89
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,160,838,785.75</b>	<b>2,719,304,559.70</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,819,108,568.00</b>	<b>8,198,776,215.39</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>	-	-
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.1.1	Дансны өглөг	117,434,000.00	3,113,412.87
2.1.1.2	Цалингийн өглөг	-	0.78
2.1.1.3	Татварын өр	290,029,137.00	573,617,397.62
2.1.1.12	Бусад богино хугацаат өр төлбөр	900,000.00	900,000.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>408,363,137.00</b>	<b>577,630,811.27</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>408,363,137.00</b>	<b>577,630,811.27</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	-	-
2.3.1	Өмч:төрийн	1,021,700,000.00	1,021,700,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,486,680.00	13,103,193.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	10,000.00	10,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	4,385,548,751.00	6,586,332,211.12
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>5,410,745,431.00</b>	<b>7,621,145,404.12</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,819,108,568.00</b>	<b>8,198,776,215.39</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>6,444,612,707.44</b>	<b>5,881,326,965.37</b>
2	Борлуулалтын өртөг	-	-
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>6,444,612,707.44</b>	<b>5,881,326,965.37</b>
5	Хүүний орлого	149,509,539.41	27,457,250.61
8	Бусад орлого	-	282,151,284.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,528,649,241.29	3,100,865,169.10
12	Бусад зардал	136,966,298.25	169,203,444.74
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>928,506,707.31</b>	<b>2,920,866,886.14</b>
19	Орлогын татварын зардал	93,126,455.78	292,393,300.25
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>835,380,251.53</b>	<b>2,628,473,585.89</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>835,380,251.53</b>	<b>2,628,473,585.89</b>
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>835,380,251.53</b>	<b>2,628,473,585.89</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	1,021,700,000.00	-	10,000.00	8,290,775,899.47	9,312,485,899.47
<b>Залруулсан үлдэгдэл</b>	1,021,700,000.00	-	10,000.00	8,290,775,899.47	9,312,485,899.47
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	835,380,251.53	835,380,251.53
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	(4,740,607,400.00)	(4,740,607,400.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	3,486,680.00	-	-	3,486,680.00
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	1,021,700,000.00	3,486,680.00	10,000.00	4,385,548,751.00	5,410,745,431.00
<b>Залруулсан үлдэгдэл</b>	1,021,700,000.00	3,486,680.00	10,000.00	4,385,548,751.00	5,410,745,431.00
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	2,628,473,585.89	2,628,473,585.89
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	(10,000,000.00)	(10,000,000.00)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(417,690,125.77)	(417,690,125.77)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	9,616,513.00	-	-	9,616,513.00
<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	1,021,700,000.00	13,103,193.00	10,000.00	6,586,332,211.12	7,621,145,404.12

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>215,027,059,571.82</b>	<b>259,767,033,007.98</b>
1.2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,229,338,396.60	5,504,815,175.03
	Бусад мөнгөн орлого	208,797,721,175.22	254,262,217,832.95
	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>218,855,174,464.55</b>	<b>256,978,656,946.78</b>
1.3	Ажиллагчдад төлсөн	1,415,871,789.00	1,015,901,332.22
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	434,367,659.37	300,622,458.94
	Бараа материал худалдан авахад төлсөн	22,619,577.00	20,450,833.91
	Ашиглалтын зардалд төлсөн	71,702,850.27	18,144,059.67
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,250,000.00	1,622,727.27
	Татварын байгууллагад төлсөн	153,611,349.92	122,434,113.11
	Бусад мөнгөн зарлага	216,754,751,238.99	255,499,481,421.66
	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(3,828,114,892.73)</b>	<b>2,788,376,061.20</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>149,509,539.41</b>	<b>27,457,250.61</b>
	Хүлээн авсан хүүний орлого	149,509,539.41	27,457,250.61
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>356,979,670.00</b>	<b>19,640,909.09</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	337,479,670.00	19,640,909.09
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	19,500,000.00	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(207,470,130.59)</b>	<b>7,816,341.52</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	<b>417,690,125.77</b>
	Төлсөн ногдол ашиг		417,690,125.77
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>(417,690,125.77)</b>
4	<b>Валютын ханшийн зөрүү</b>		
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(4,035,585,023.32)</b>	<b>2,378,502,276.95</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>4,460,352,687.07</b>	<b>424,767,663.75</b>
7	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>424,767,663.75</b>	<b>2,803,269,940.70</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>							
1	<b>а) Арилжааны хэмжээ</b>	<b>тн</b>	<b>18,106.50</b>	<b>19,908.00</b>	<b>16,310.00</b>	<b>(3,598.00)</b>	<b>82</b>
	Ноолуур	тн	2,931.50	3,000.00	3,258.00	258.00	109
	Хонины ноос	тн	6,340.00	8,257.00	4,240.00	(4,017.00)	51
	Тэмээний ноос	тн	1,021.00	934.00	1,007.00	73.00	108
	Ямааны завод ноос	тн	3,365.00	2,192.00	1,956.00	(236.00)	89
	Хонины завод ноос	тн	27.00	30.00	-	(30.00)	-
	Тосны ургамал	тн	4,422.00	5,495.00	5,849.00	354.00	106
	<b>б) Арилжааны дүн</b>	<b>тб.төг</b>	<b>994.92</b>	<b>793.59</b>	<b>1,039.63</b>	<b>246.04</b>	<b>131</b>
	Ноолуур	тб.төг	889.69	714.00	963.37	249.37	135
	Хонины ноос	тб.төг	13.71	14.99	9.77	(5.22)	65
	Ямааны завод ноос	тб.төг	71.31	46.69	41.58	(5.11)	89
	Тэмээний ноос	тб.төг	12.60	8.98	14.98	6.00	167
	Хонины завод ноос	тб.төг	0.03	0.03	-	(0.03)	-
	Тосны ургамал	тб.төг	7.58	8.90	9.93	1.03	112
2	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>6,594,122.25</b>	<b>4,727,839.54</b>	<b>6,190,935.50</b>	<b>1,463,095.96</b>	<b>131</b>
3	<b>Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>5,665,615.54</b>	<b>4,310,728.70</b>	<b>3,270,068.61</b>	<b>(1,040,660.09)</b>	<b>76</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	78,910.23	78,000.00	75,872.00	(2,128.00)	97
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>м.төг</b>	<b>928,506.71</b>	<b>417,110.84</b>	<b>2,920,866.89</b>	<b>2,503,756.04</b>	<b>700</b>
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>м.төг</b>	<b>835,380.25</b>	<b>375,399.76</b>	<b>2,628,473.59</b>	<b>2,253,073.83</b>	<b>700</b>
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>м.төг</b>	<b>698,575.41</b>	<b>556,508.82</b>	<b>722,209.07</b>	<b>165,700.25</b>	<b>130</b>
	а/ Орлогын татварт	м.төг	93,126.46	41,711.08	292,393.30	250,682.22	701
	в/ НДШ	м.төг	434,367.66	368,173.38	300,622.46	(67,550.92)	82
	г/ Хувь хүний орлогын татвар	м.төг	164,322.09	139,865.15	122,434.11	(17,431.04)	88
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	6,759.20	6,759.20	6,759.20	-	100

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	-	187,699.88	1,314,236.79	1,126,536.91	700
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	28.00	24.00	21.00	(3.00)	88
9	Нийт цалингийн сан	м.төг	1,692,488.49	1,372,760.00	1,130,234.28	(242,525.72)	82
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	4,317.57	4,085.60	3,844.33	(241.26)	94
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.86	0.91	0.53	(0.38)	58
12	Хөрөнгө оруулалт	м.төг	360,466.35	19,900.00	19,640.91	(259.09)	99
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>2,173,640.53</b>	<b>2,141,193.77</b>	<b>2,461,614.13</b>	<b>320,420.36</b>	<b>115</b>
	Үүнээс: Найдваргүй	м.төг	493,488.11	-	659,625.44	659,625.44	-
14	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	<b>408,363.14</b>	<b>-</b>	<b>577,630.81</b>	<b>577,630.81</b>	<b>-</b>
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	408,363.14	-	577,630.81	577,630.81	-
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	-	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь эрхэм зорилгоо “Монгол Улсад олон улсын стандартад нийцсэн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бий болгох, бараа түүхий эдийн арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд /танхимын болон цахим сүлжээгээр/ зохион байгуулах, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх” гэж тодорхойлон үйл ажиллагаа явуулж байгаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо бий болгох, бараа, түүхий эдийн спот болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг эрхлэх, арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд танхимын болон цахим сүлжээгээр зохион байгуулах” гэж тодорхойлжээ.

#### 3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь дараах хууль эрх, зүйн орчны хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Компанийн тухай хууль;
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 3 дугаар тогтоол,

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2019 онд боловсруулсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.379.1 сая төгрөгөөр буюу 40.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	424,767.7	2,803,269.9	2,378,502.2
Авлага	2,190,680.3	2,663,121.1	472,440.8
Бараа материал	42,821.3	2,618.4	(40,202.9)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	10,462.2	10,462.2
Үндсэн хөрөнгө	3,160,838.8	2,719,304.6	(441,534.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,819,108.6</b>	<b>8,198,776.2</b>	<b>2,379,667.6</b>
Өр төлбөр	408,363.2	577,630.8	169,267.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,410,745.4	7,621,145.4	2,210,400.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,819,108.6</b>	<b>8,198,776.2</b>	<b>2,379,667.6</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нь 2,803.3 сая төгрөг болж 2,378.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд гүйцэтгэлээр 6,190.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,270.0 сая төгрөгийн зардал гарган, 2,628.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласантай холбоотой;

Авлага дансны үлдэгдэл 2,663.1 сая төгрөг болж өмнөх оноос 472.4 сая төгрөгөөр өссөн нь 2024 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэхтэй холбогдуулан орон сууц худалдан авах урьдчилгаа өгсөн. Үүнээс өөр байгууллагад шилжин ажиллахаар болсон 4 албан хаагчийн орон сууцны урьдчилгаа болох 282.2 сая төгрөгөөр бусад богино хугацаат авлага, мөн арилжааны шимтгэлийн орлогын авлага нэмэгдсэнтэй холбоотой;

Бараа, материалын дансны үлдэгдэл 2.6 сая төгрөг болж өмнөх оноос 40.2 сая төгрөгөөр буурсан нь 12.2 сая төгрөгийн бараа худалдан авч, 52.4 сая төгрөгийн барааг зарцуултай холбоотой;

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 2,719.3 сая төгрөг болж 441.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд шинээр 29.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авч, 24.7 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний хасагдуулга хийж, нийт 470.8 сая төгрөгийн хөрөнгийн элэгдэл байгуулсантай холбоотой;

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 577.6 сая төгрөг болж 169.3 сая төгрөгөөр өссөн нь дансны өр төлбөр 114.3 сая төгрөгөөр буурч, татварын өр төлбөр 283.6 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой;

Эздийн өмч дансны үлдэгдэл 7,621.1 сая төгрөг болж 2,210.4 сая төгрөгөөр өссөн нь дахин үнэлгээний хэрэгжсэн нэмэгдэл 9.6 сая төгрөг, тайлант үеийн үр дүн 2,628.5 сая төгрөгөөр нэмэгдсэн зэргээс тус тус шалтгаалсан байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

#### **3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК нь техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2025 оны “Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталсан, 2025 оны 3 дугаар сарын 10-ны 04 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна.

Тодотголоор орлогыг 488.8 сая төгрөгөөр бууруулан баталж тайлант оны нийт орлогыг 4,727.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,310.7 сая төгрөгөөр, 375.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 19.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

#### **3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр 6,190.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,270.0 сая төгрөгийн зардал гарган, 2,628.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 6,190.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,463.1 сая төгрөг буюу 31 хувиар давсан нь арилжааны шимтгэлийн орлого 1,102.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 2024 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэхтэй холбогдуулан орон сууц худалдан авах урьдчилгаа өгсөн. Үүнээс өөр байгууллагад шилжин ажиллахаар болсон 4 албан хаагчийн орон сууцны урьдчилгаа болох 282.2 сая төгрөгөөр бусад орлого нэмэгдэж, ноолуурын зах зээлийн үнийн өсөлтөөс арилжааны шимтгэлийн орлого 35 хувиар өссөн зэргээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 3,270.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,040.7 сая төгрөг дутуу зардал гаргасан байна. Энэ нь компани Дархан-Уул аймагт шилжин суурьшсантай холбогдуулан орон тоо цөөрсөн, хөтөлбөр арга хэмжээний зардал, албан томилолтын зардлууд нөлөөлжээ.

Хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээнд 1 ажил төлөвлөж өөрийн эх үүсвэрээс 19.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 2,628.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,253.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь борлуулалтын орлогыг 1,463.1 сая төгрөгөөр давуулан биелүүлж, нийт зардлыг 1,040.7 сая төгрөгөөр хэмнэж ажилласан нь нөлөөлжээ.

Тайлант онд Сангийн яамны Төрийн сангийн улсын төсвийн орлогын дансанд өмнөх оны ногдол ашиг 835,4 сая төгрөгийн цэвэр ашгийн 20 хувь болох 167.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1, Компанийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.4.3, Хөдөлмөрийн дотоод журмын 7.2.1 заалтуудыг тус тус үндэслэн Гүйцэтгэх захирлын 2023 оны А/142 тоот тушаалаар албан хаагчдын ажилдаа ирэх буцах нийтийн тээврийн унааны зардлыг өдрийн 8.0 мянган төгрөг,

- хоолны зардлыг 12.0 мянган төгрөг байхаар баталж, тайлант хугацаанд унаа хоолны зардалд 115.9 сая төгрөг төлөвлөж, 74.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.
2. Тайлант хугацаанд гадаад албан томилолтонд 68.0 сая төгрөг зарцуулсан байна.
  3. Тайлант хугацаанд хамаарах төрд учирсан хохирол байхгүй байна.
  4. Программ хангамжийн 4 үндсэн программаас тайлант онд дараах 3 программд 265.0 сая төгрөгийн засвар үйлчилгээний зардал гаргасан байна. Үүнд:
    - Арилжаа, төлбөр тооцооны үндсэн системд 80.0 сая төгрөг
    - “Багцын гэрээний систем” нь компанийн үндсэн үйл ажиллагаанд ашиглагддаг “Арилжаа төлбөр тооцооны цогц систем”-тэй уялдан ажиллах татварын бүртгэлийн системд 5.0 сая төгрөг
    - “Экспортын нэг цонхны систем” нь импорт, экспорт, транзиттэй холбоотой зохицуулалтын бүх шаардлагыг биелүүлэхийн тулд нэг цэгээр дамжуулан төрийн байгууллага болон албан ёсны агентлагуудад мэдээлэл солилцох боломжийг олгодог системд 180.0 сая төгрөг
  5. Гүйцэтгэх захирлын 2025 оны А/25, А/49 тоот тушаалаар сургалт, семинарын зардал 17.7 сая төгрөг, А/06, А/24 тоот тушаалаар хурал, зөвлөгөөн, түүнтэй адилтгах арга хэмжээний зардалд 16.1 сая төгрөгийг зарцуулсан байна.
  6. Компани нь 2024 онд нийт 42 ажилтантай байсан бөгөөд 2024 оны 10 дугаар сард Дархан-Уул аймагт шилжин суурьшсантай холбогдуулан бүтэц орон тоог 24 болгон бууруулж ажилсан ба тайлант онд алба хаагчдын тоог 9 хувиар бууруулаагүй байна.
  7. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний 7.4 сая төгрөгийн 2 гэрээ байгуулж, төлбөр тооцоо гаргасан байна.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу НТШ-ийн аргаар 2, ГШБ аргаар 2, ШХА аргаар 18 тус тус зохион байгууллахаар 958.0 сая төгрөгийг төлөвлөж батлуулсан. Үүнээс ГШБ аргаар 260.0 сая төгрөгийн 2 гэрээ, ШХА аргаар 94.4 сая төгрөгийн 8 гэрээ, нийт 354.4 сая төгрөгийн 10 гэрээ хийсэн байна.

## 4.АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дөлгөөнхайрхан уул аудит” ХХК-ийн ахлах аудитор Н.Янжмаа, туслах аудитор А.Золзаяа нар гүйцэтгэж, аудитын менежер С.Долгорсүрэн, захирал Б.Пүрэвдулам нар анхан шатны хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Батцэцэг, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 5,665.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 56.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу компани тайлант онд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж цалин ЭМНДШ-ийн зардлыг 267.6 сая төгрөгөөр, хөтөлбөр арга хэмжээний зардлыг 555.9 сая төгрөг, түрээсийн зардлыг 7.1 сая төгрөгөөр, албан томилолтын зардлыг 201.3 сая төгрөг, нийгмийн хамгаалал, хүний нөөцийн үйл ажиллагааны зардлыг 4.3 сая төгрөгөөр, программ хөгжүүлэлтийн зардлыг 24.9 сая төгрөгөөр, ашиглалтын зардлыг 29.2 сая төгрөгөөр, засварын зардлыг 21.9 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 68.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж нийт 1,040.7 сая төгрөгийн хэмнэлтийг гарган ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн алдаа зөрчилгүй.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлсэн эсэхийг хамруулан шалгалаа. Шилэн дансны цахим хуудсанд нийт 182 мэдээлэлийг бүрэн хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт****4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,652.8 сая төгрөгийн 3 албан шаардлага, 2 зөвлөмжийг нотлох баримтад үндэслэн хэрэгжилтийн үнэлэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	3,186,137.5	3	3,186,137.5	100.0
Зөвлөмж	2	466,698.6	2	466,698.6	100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>3,652,836.1</b>	<b>5</b>	<b>3,652,836.1</b>	<b>100.0</b>

## 5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 289.2 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 3 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн 289.2 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 232.5 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. “Эх буудайн хур” ХХК-тай 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр №25/25 тоот “Нарс, Голт бор худалдан авах” гэрээ байгуулсан байна. Гэрээнд 54 ширхэг модыг нэг бүрийн үнэ 0.3 сая төгрөг, нийт 17.9 сая төгрөгийн худалдан авах гэрээ байгуулж харьцуулсан судалгаа хийлгүйгээр зах зээлийн үнээс өндөр үнээр авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 5.1.5-д “хэмжигдэхүйц байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын гэрээ хэлэлцээрийг хийхдээ зах зээлийн судалгаа хангалттай хийгээгүй, зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авалт хийдэг зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. "Дижитал Медик" ХХК-тай 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр №25/12 тоот дугаартай 80.0 сая төгрөгийн "Системийн хэвийн ажиллагаа хангах" гэрээ, "Айтүүлс" ХХК-тай №25/13 тоот дугаартай 180.0 сая төгрөгийн “Системийн ашиглалтад дэмжлэг үйлчилгээ үзүүлэх” гэрээнүүдийг нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар байгуулсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гэрээг байгуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт гэрээний хувийг, уг аргыг хэрэглэх болсон үндэслэлтэй хамт хүргүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-д “Захиалагч энэ хуулийн 35, 36 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний хувийг, уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэх болсон үндэслэл, байгуулсан гэрээний хувийг ажлын 10 хоногт багтаан Авлигатай тэмцэх газарт хүргүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Дотоод томилолтоор явсан автомашины шатахууны зардалд нийт 11.3 сая төгрөгийг зарцуулсан. Томилолтоор явахдаа ашигласан автомашины мэдээлэл байхгүй, шатахууныг тушаалын хавсралтад автомашинд 100 км-д 25 литр бензин зарцуулна гэж гаргасны дагуу тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлийн тухай хуулийн 4.2.7-д “аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 3.2-т “Албан ажлын хэрэгцээнд хувийн

автомашин хэрэглэсэн тохиолдолд шаардагдах шатахуун, эсхүл уг шатахууны үнийг эрх бүхий байгууллагаас баталсан тарифын дагуу нөхөн олгоно”, Зам тээвэр, хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт автомашин 100км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, журмын дагуу томилолтоор явахдаа ашигласан авто машины марк, загвар, зарцуулах шатахууны жишиг нормыг харгалзан тооцож гаргаагүй зөрчлийг арилгах, албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
“Эх буудайн хур” ХХК-тай 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр №25/25 тоот “Нарс, Голт бор худалдан авах” гэрээ байгуулсан байна. Гэрээнд 54 ширхэг модыг нэг бүрийн үнэ 0.3 сая төгрөг, нийт 17.9 төгрөгийн худалдан авах гэрээ байгуулж харьцуулсан судалгаа хийлгүйгээр зах зээлийн үнээс өндөр үнээр авсан байна.	1	17,858.0	-	-	1	17,858.0	-	-	-	-	-	-
Нийт 260.0 сая төгрөг бүхий үнийн дүнтэй 2 гэрээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйл Нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар байгуулсан байна. Гэрээнүүдийг нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар байгуулсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гэрээг байгуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор Авлигатай тэмцэх газар гэрээний хувийг, уг аргыг хэрэглэх болсон үндэслэлтэй хамт хүргүүлээгүй байна.	1	260,000.0	-	-	1	260,000.0	-	-	-	-	-	-
Дотоод томилолтоор явсан автомашины шатахууны зардалд нийт 11.3 сая төгрөгийг зарцуулсан. Томилолтоор явахдаа ашигласан автомашины мэдээлэл байхгүй, шатахууныг тушаалын хавсралтад автомашинд 100 км-д 25 литр бензин зарцуулна гэж гаргасны дагуу тооцож олгосон байна.	1	11,331.3	-	-	1	11,331.3	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>289,189.3</b>	-	-	<b>3</b>	<b>289,189.3</b>	-	-	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 702/A0150079

Улаанбаатар хот

САГ-2026/80/НА -СТА -ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд "Эх буудайн хур" ХХК-тай 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр №25/25 тоот "Нарс, Голт бор худалдан авах" гэрээ байгуулсан байна. Гэрээнд 54 ширхэг модыг нэг бүрийн үнэ 330,704.00 /гурван зуун гучин мянга долоон зуун дөрвөн/ төгрөг, нийт 17,858,000.00 /арван долоон сая найман зуун тавин найман мянган/ төгрөгийн худалдан авах гэрээ байгуулж харьцуулсан судалгаа хийлгүйгээр зах зээлийн үнээс өндөр үнээр авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" гэсэнтэй нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.4-т "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Худалдан авалтын гэрээ хэлэлцээрийг хийхдээ зах зээлийн судалгаа хангалттай хийгээгүй, зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авалт хийдэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Э.Нарангарав/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Номин-Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

Б.ПҮРЭВДУЛАМ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 703/АД150079

Улаанбаатар хот

САГ - 2026/80/НА - СТА - ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд "Дижитал Медик" ХХК-тай 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр №25/12 тоот дугаартай 80,000,000.00 /наян сая/ төгрөгийн "Системийн хэвийн ажиллагаа хангах" гэрээ, "Айтүүлс" ХХК-тай №25/13 тоот дугаартай 180,000,000.00 /нэг зуун наян сая/ төгрөгийн "Системийн ашиглалтад дэмжлэг үйлчилгээ үзүүлэх" гэрээнүүдийг нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар байгуулсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гэрээг байгуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор Авлигатай тэмцэх газар гэрээний хувийг, уг аргыг хэрэглэх болсон үндэслэлтэй хамт хүргүүлээгүй байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-д "Захиалагч энэ хуулийн 35, 36 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний хувийг, уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.9.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар шууд гэрээ байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гэрээний хувийг, уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт ажлын 10 хоногт багтаан Авлигатай тэмцэх газарт хүргүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Э.Нарангарав/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Номин-Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
Б.ПҮРЭВДУЛАМ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 704/АД150079

Улаанбаатар хот

САГ-2026/80/НА - СТА - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны дотоод томилолтоор явсан автомашины шатахууны зардалд нийт 11,331,320.00 /арван нэгэн сая гурван зуун гучин нэгэн мянга гурван зуун хорин/ төгрөгийг зарцуулсан. Томилолтоор явахдаа ашигласан автомашины мэдээлэл байхгүй, шатахууныг тушаалын хавсралтад автомашинд 100 км-д 25 литр бензин зарцуулна гэж гаргасны дагуу тооцож олгосон байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлийн тухай хуулийн 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 3.2-т "Албан ажлын хэрэгцээнд хувийн автомашин хэрэглэсэн тохиолдолд шаардагдах шатахуун, эсхүл уг шатахууны үнийг эрх бүхий байгууллагаас баталсан тарифын дагуу нөхөн олгоно", Зам тээвэр, хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт автомашин 100км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм гэсэнтэй нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.5.төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Холбогдох хууль, журмын дагуу томилолтоор явахдаа ашигласан авто машины марк, загвар, зарцуулах шатахууны жишиг нормыг харгалзан тооцож гаргаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Э.Нарангарав/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Номин-Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

Б.ПҮРЭВДУЛАМ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-29.Docx

1526180854